



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/317

Булган сум

Ариун цэврийн өрөөгөөр чөлөөтэй үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” 474 дүгээр тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 07 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төвлөрсөн болон бие даасан ариутгах системд холбогдох боломжгүй газар үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц, худалдаа үйлдвэрлэл, амралт аялал жуулчлалын газруудыг MNS5924:2015 шаардлага хангасан стандартын байгууламж, бохирын цооногтой болгох ажлыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Иргэд, үйлчлүүлэгч, зорчигчдын эрх ашгийг хамгаалах, ая тухтай үйлчлүүлэх зорилгоор Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу үйл ажиллагаа явуулж байгаа зоогийн газар, шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар иргэд, үйлчлүүлэгчдэд чөлөөтэй, нээлттэй үйлчилгээ үзүүлэхийг аж ахуйн нэгжийн удирдлагад даалгасугай.

3.Дээрх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр), Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлан ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010448